



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/85

Булган сум


WANNABE GROUP-ийн төлөөллийг хүлээн авах зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XVIII/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас “Монголд зочлох” жил болгон зарласантай холбогдуулан аялал жуулчлалыг дэмжих “Нэг жуулчин-Нэг хонь” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Булган аймагтай хамтран ажиллах, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтын ажиллагааны талаар харилцан санал солилцох, нөхцөл байдалтай танилцахаар зочлон ирж буй Бүгд Найрамдах Солонгос Улсын WANNABE GROUP-ийн төлөөллийг хүндэтгэн хүлээн авах шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Зочид төлөөлөгчдийг хүлээн авахад шаардагдах 11,355,740 (арван нэгэн сая гурван зуун тавин таван мянга долон зуун дөч) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 21-ны өдрийн А.Б.С. дугаар
захирамжийн хавсралт

ЗОЧИД ТӨЛӨӨЛӨГЧДИЙГ ХҮЛЭЭН АВАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Өдрийн хоол /Дайчин ван/	20 хүн	88,575	1,771,500
2	Байрны зардал /Севэн нуга/	3 байшин, 3 цомцог гэр	Байшин- 1,200,000, Гэр- 560,000	5,280,000
3	Оройн хоол /Севэн нуга/	-	-	2,469,300
4	Гарын бэлэг	11 хүн	109,000	1,009,000
5	Шатахуун /Булган-Хялганат-Булган/ 2 машин	300 км	АИ92 77*2520 ДТ 100*4510	645,040
6	Цай, ус	-	-	180,900
Нийт зардал				11,355,740 төгрөг